



МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар: 01/2022

Улаанбаатар хот

МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙГ БАТЛАХ, ХАРИУЦЛАГАТАЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Нэг. Монголын Уулчдын Үндэсний Холбооны дүрмийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Уулчдын Үндэсний Холбооны зохион байгуулалтын бүтцийг Хавсралт ёсоор баталсугай.
2. Холбооны дараах хариуцлагатай албан тушаалд дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай.
 - 2.1. Ерөнхийлөгчийн Зөвлөхөөр Т.Жамбаажамц
 - 2.2. Холбооны Өндөр уулын авиралт, хайкинг төрөл хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр Удирдах зөвлөлийн гишүүн Ш.Батзориг
 - 2.3. Холбооны Тэмцээнт төрөл хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр Удирдах зөвлөлийн гишүүн Т.Мөнхтөр
 - 2.4. Холбооны Сургалт, Эрүүл мэнд хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр Удирдах зөвлөлийн гишүүн Г.Мөнхжаргал
 - 2.5. Холбооны Аврах, аюулгүй ажиллагаа, эрсдлийн удирдлага хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр Удирдах зөвлөлийн гишүүн С.Ганхүү
 - 2.6. Скайраннинг, Уулын цана хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр Удирдах зөвлөлийн гишүүн Э.Хосбаяр
 - 2.7. Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар У.Ариунзоригт
 - 2.8. Холбооны Гүйцэтгэх нарийн бичгийн даргаар Б.Эрдэнэцэцэгийг тус тус.
3. Холбооны зөвлөл, хороодод ажиллах хүмүүсийг дараах жагсаалтын дагуу томилсугай.
 - 3.1. Мэргэжлийн зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн Б.Ганзориг
 - 3.2. Шүүгчдийн зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн С.Саранцэцэг
 - 3.3. Цол зэргийн зөвлөлийн даргаар Удирдах зөвлөлийн гишүүн Б.Гангаамаа
 - 3.4. Ахмадын зөвлөлийн даргаар ахмад уулчин Уулын спортын мастер Д.Чагнаа

Хоёр. Монголын Уулчдын Үндэсний Холбооны зохион байгуулалтын бүтцийн дагуу томилогдсон албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий нарийн бичгийн дарга /У.Ариунзоригт/-д даалгасугай.


УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТУЛГА



2022 оны 3-р сарын 11-ний өдрийн
Удирдах зөвлөлийн хурлын 01 тоот
Тогтоолын Хавсралт





МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар: 02/2022

Улаанбаатар хот

МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТЛАХ ТУХАЙ

Нэг. Монголын Уулчдын Үндэсний Холбооны дүрмийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Уулчдын Үндэсний Холбооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Монголын Уулчдын Үндэсний Холбооны 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Удирдах зөвлөлийн гишүүд, Ерөнхий нарийн бичгийн дарга /У.Ариунзоригт/, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэцэцэг/-д үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТУЛГА



МОНГОЛЫН УУЛЧДЫН
УНАЭСНИЙ ХОЛБОО

БАТЛАВ.

ЕРӨНХИЙЛӨГЧ



2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Улирал	Сар	Өдөр	Арга хэмжээний нэр	Хариуцах газар	Байршил
1	I улирал	3	11	Удирдах зөвлөлийн хурал	Удирдах зөвлөл	Монгол улс, Улаанбаатар хот
2		3	14-31	Орон тооны 2 албан тушаал дээр нээлттэй ажлын байр зарлаж сонгон шалгаруулалт хийх.	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
3		3	17-18	Олон улсын спорт авиралтын холбооны /IFSC/ Ерөнхий ассамблей	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	АНУ, онлайн
4		3	19	Алтан Өлгий 2022 уулын гүйлтийн тэмцээн	Скайраннингийн хороо	Алтан-Өлгий хайрхан, Хэнтий нуруу Эрдэнэ сум, Төв аймаг
5		3	21	МУБИС-ын спорт авиралт заалны гэрээ сунгах	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
6		3	23	Олон улсын уулын холбооны гарын авлагыг Монгол хэлэнд орчуулсан номын нээлт	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
7		3	24-31	UIAA болон "Petzl foundation" сургалт бэлтгэл ажил эхлэх	Сургалтын хороо	Монгол улс, Улаанбаатар хот
8		4	06	Удирдах зөвлөлийн хурал	Удирдах зөвлөл	Монгол улс, Улаанбаатар хот
9		4	06	Холбооны Удирдах зөвлөл гишүүн, гишүүн бус клубийн удирдлагуудтай уулзалт хийх	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
10		4	09	2022 оны Спорт авиралтын Улаанбаатар хотын АШТ	Спорт авиралт, хаданд авиралтын хороо ба бусад	Монгол улс, Улаанбаатар хот
11	II улирал	4	11-31	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь өндөр уулын бүсэд авиралт хийх, аялах журам батлуулах	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
12		4	14	МУУХ-ны 1-р улиралын санхүү, үйл ажилгааны тайлан боловсруулж вэб хуудсанд байршуулах	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
13		4	30	"Дуган хад" 45 км уртын алхалт	Саммит клуб, Хайкинг хороо	Монгол улс, Төв аймаг
14		5	06-08	Спорт авиралт Дэлхийн цомын тэмцээн	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	Солонгос улс
15		5	07-08	Сагсан бөмбөгийн тэмцээн	Улаанбаатар аялагч клуб	Монгол улс, Улаанбаатар хот
16		5	14-15	2022 оны Спорт авиралтын УАШТ	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	Монгол улс, Улаанбаатар хот
17		5	20-22	Спорт авиралт Дэлхийн цомын тэмцээн	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	АНУ
18		5	27-29	Спорт авиралт Дэлхийн цомын тэмцээн	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	АНУ
19		5	28	МУУХ Менежментийн багийн уулзалт	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
20		6	10-20	UIAA болон "Petzl foundation" сургалт	Сургалтын хороо	Алтай таван богд Баян-Өлгий
21		6	21-24	Альпинад 2022	Өндөр уулын авиралтын хороо	Алтай таван богд Баян-Өлгий
22		6	22-26	Спорт авиралт Оюутаны Дэлхийн аварга	Спорт авиралт, хаданд авиралтын хороо	Австри улс
23		6	23-07.03	Алтай Таван Богдын сургалт авиралт / Хүйтэн, Найрамдал, Малчин, Наран оргилууд /	Гангаамаа сан, Сургалтын хороо	Алтай таван богд Баян-Өлгий
24		6	31	Шинээр клуб элсүүлэх	Гишүүнчлэлийн хороо	Монгол улс, Улаанбаатар хот
25	III улирал	1-7 сар	1.25-7.25	Памирын уулс Ленин оргил /7134 м дтд/, Хан тэнгэр /7010 м дтд/ авиралт хийх зорилго бүхий уулчдыг бэлтгэх сургалт	Жаргалант клуб	Монгол улс, Улаанбаатар хот
26		7	20	МУУХ-ны 2-р улиралын санхүү, үйл ажилгааны тайлан боловсруулж вэб хуудсанд байршуулах	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
27		8	1	Олон улсын стандарт хана барих төслийн ажил эхлүүлэх	Тэмцээнт төрөл хариуцсан хороо, Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот
28		8	13-14	Хаданд авиралтын зуны наадам	Улаанбаатар аялагч клуб, Спорт авиралт, хаданд авиралтын хороо	Монгол улс, Улаанбаатар хот
29		9	10	Гарамын Барсболдын нэрэмжит уулын эрчимт алхалтын улсын аварга шалгаруулах тэмцээн	Хайрхан аялагч клуб	Монгол улс, Улаанбаатар хот
30		9	10-26	Азийн зуны наадам	Спорт авиралтын хороо	БНХАУ Ханжоу хот
31		9	16	Удирдах зөвлөлийн хурал	Удирдах зөвлөл	Монгол улс, Улаанбаатар хот
32		9	30	Богдхан уулын алхалтын замууд, зөвлөмж бүхий газрын зураг, зөвлөмж бэлтгэж хэвлүүлэх	Хайкинг хороо	Монгол улс, Улаанбаатар хот
33	IV улирал	10	01	Азийн уулын холбооны Ерөнхий ассамблей	Удирдах зөвлөл	
34		10	01	Уулын замуудыг тодорхойлох, тракжуулах, зэрэглэл	Өндөр уулын авиралтын хороо	Монгол улс, Улаанбаатар хот
35		10	29	Олон улсын уулын холбооны Ерөнхий ассамблей	Удирдах зөвлөл	Канад
36		11	05	"Улаанбаатар аялагч клуб"-ын нэрэмжит бага насны хүүхдүүдийн Спорт авиралтын тэмцээн	Улаанбаатар аялагч клуб, Спорт авиралт, хаданд авиралтын хороо	Монгол улс, Улаанбаатар хот
37		12	8	Олон улсын уулын өдрийг угтсан арга хэмжээнүүдийн нээлт	Ажлын алба	Монгол улс
38		12	22	Golden Ice Axe Шилдэг авиралт шалгаруулах ёслолын ажиллагаа	Ажлын алба	Монгол улс, Улаанбаатар хот



МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар: 03/2022

Улаанбаатар хот


МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНЫ 2022 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Нэг. Монголын Уулчдын Үндэсний Холбооны дүрмийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын Уулчдын Үндэсний Холбооны 2022 оны санхүүгийн төсвийг Хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Монголын Уулчдын Үндэсний Холбооны батлагдсан төсвийн дагуу ажиллахыг Ерөнхий нарийн бичгийн дарга /У.Ариунзоригт/, Гүйцэтгэх нарийн бичгийн дарга /Б.Эрдэнэцэцэг/ нарт үүрэг болгосугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТУЛГА



МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03-р сарын 11-ний өдөр

Дугаар: 04/2022

Улаанбаатар хот

Монголын Уулчдын Үндэсний Холбооны гишүүнчлэлийн журамыг шинэчлэн батлах тухай

Монголын Уулчдын Үндэсний Холбооны дүрмийг үндэслэн ТОГТООХ нь

1. Монголын Уулчдын Үндэсний Холбооны гишүүнчлэлийн журмын 5.1 заалт гишүүнчлэлийн хураамж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гишүүн байгууллага нэг жилд хураамж нь 300 000 төг, орон нутагт үйл ажиллагаа гишүүн байгууллага нэг жилд хураамж нь 240 000 төг болгон нэмэгдүүлэхээр ажлын албаны өргөн барьснаар шинэчлэн баталсугай
2. Батлагдсан гишүүнчлэлийн журамыг гишүүн байгууллага, клуб-т хүргүүлэх болон олон нийтийн сүлжээнд байршуулах ажлыг ажлын албанд даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТУЛГА



www.olympic.mn



www.theuiaa.org

Гишүүнчлэл



www.ifsc-climbing.org



UNION OF ASIAN ALPINE ASSOCIATIONS
www.theuaaa.org

www.theuaaa.org



МОНГОЛЫН УУЛЧДЫН
ҮНДЭСНИЙ ХОЛБОО

Холбоо барих:

Утас: +976-99957777

Имэйл: sg@mountain.mn

Вэб сайт: www.mountain.mn

МОНГОЛЫН УУЛЧДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБОО НҮ ТББ-ЫН 2022 ОНЫ 03-Р САРЫН 11 ӨДРИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЙН ХУРЛЫН 4 ТООТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ - 1

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монголын Уулчдын Үндэсний Холбоо” НҮ ТББ /цаашид МУҮХолбоо гэх/ -ний гишүүн байгууллага элсүүлэх элсүүлэх, тэдгээрийн ангилал, гишүүний эрх, үүрэг, элсэлтийн хураамж, гишүүний татвар, хандив болон бусад гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

ХОЁР. ГИШҮҮН

- 2.1. МУҮХолбоо нь холбоо, клуб, нийгэмлэг болон байгууллагуудыг гишүүн байгууллагаар элсүүлнэ.
- 2.2. Гишүүн нь МУҮХолбооны зорилго, үйл ажиллагааг дэмжин ажилладаг холбоо, клуб, нийгэмлэг болон байгууллагууд байна.

ГУРАВ. ГИШҮҮНИЙГ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ БОЛОН ГИШҮҮНИЙ БҮРТГЭЛ

МУҮХолбоо нь гишүүнийг элсүүлэхдээ дараах журмаар элсүүлнэ.

- 3.1. Энэхүү журмын 2.1.-т заасан холбоо, клуб, нийгэмлэг болон байгууллага тус журмын дагуу элсүүлнэ.
- 3.2. Энэхүү журмын 2.1.-т заасан гишүүн байгууллагуудыг холбоонд ирүүлсэн хүсэлт /Албан бичгээр/, гишүүнчлэлийн анкет, эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоол, байгууллагын гэрчилгээний хуулбар, гишүүнчлэлийн татвар төлсөн баримт /ХААН банк дахь 5111497363 Монголын Уулчдын Үндэсний Холбоо/-уудыг хүлээн авч ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 3.3. МУҮХолбооны гишүүн нь жилийн татвараа төлсөн холбоо, клуб, нийгэмлэг болон байгууллагууд байна.
- 3.4. МУҮХолбоонд 1955 оноос хойш гишүүн байсан байгууллагууд тухайн гишүүнчлэлийн хугацаагаар гишүүнчлэлээ сэргээх боломжтой. Сэргээх тохиолдолд дахин бүртгүүлнэ.

ДӨРӨВ. ГИШҮҮН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

Холбооны гишүүн байгууллага дараах нийтлэг эрх эдлэж үүрэг хүлээнэ.

- 4.1. МУҮХолбооны гишүүн байгууллага нь дөрвөн жил тутам зохион байгууллагддаг бүх гишүүдийн хуралд саналын эрхтэй оролцох бөгөөд хуралын зохион байгуулах журамд өөрөөр заагаагүй дараах саналын эрхийг эдэлнэ.
 - 4.1.1 5 жилээс дээш хугацаанд МУҮХолбооны гишүүнчлэлтэй, гишүүний татвараа бүрэн төлсөн бол саналын 3 эрхтэй
 - 4.1.2 1-5 жилийн хугацаанд МУҮХолбооны гишүүнчлэлтэй, гишүүний татвараа бүрэн төлсөн бол саналын 2 эрхтэй
 - 4.1.3 1 жил хүртлэх хугацаанд МУҮХолбооны гишүүнчлэлтэй, гишүүний татвараа бүрэн төлсөн бол саналын 1 эрхтэй
- 4.2. МУҮХолбооны сайн дурын менежментийн багт гишүүдээ нэр дэвшүүлэх эрхтэй.
- 4.3. МУҮХолбооны үйл ажиллагааны талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авах эрхтэй;
- 4.4. МУҮХолбооноос зохион байгуулж буй арга хэмжээ, тэмцээнд оролцох, хөнгөлөлт эдлэх эрхтэй;
- 4.5. МУҮХолбооноос зохион байгуулж буй сургалт, семинар, уулзалтанд оролцох эрхтэй;
- 4.6. МУҮХолбооны гишүүн байгууллагууд болон хамтрагч байгууллагуудаас /Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичгийн дагуу/ хөнгөлөлт эдлэх эрхтэй;
- 4.7. МУҮХолбооноос зохион байгуулж буй зарим арга хэмжээг хамтран зохион байгуулах, дэмжих эрхтэй;
- 4.8. Тив, дэлхий, олон улсын чанартай тэмцээн уралдаанд шаардлага хангасан тамирчид, гишүүдээ оролцуулах эрхтэй;
- 4.9. МУҮХолбооны дүрэм журмыг чанд мөрдөх үүрэгтэй;

- 4.10. Холбооноос тогтоосон жилийн татвар хураамжийг энэхүү журамд заасан хугацаанд төлөх үүрэгтэй;

ТАВ. ГИШҮҮНИЙ ХУРААМЖ

- 5.1. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг гишүүн байгууллага нэг жилд 300,000.00 ₮ /гурван зуун мянган/ төгрөгийн гишүүнчлэлийн хураамж төлнө.
- 5.2. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг гишүүн байгууллага 240,000.00 ₮ /хоёр зуун дөчин мянга/ төгрөгийн гишүүнчлэлийн хураамж төлнө.
- 5.3. Жилийн дундуур гишүүнээр элссэн тохиолдолд гишүүнчлэлийн хураамжийг элсэн орж буй сарыг оролцуулан он дуустал үлдсэн сард оногдох хураамжийг төлнө.
- 5.4. Гишүүнчлэлийн хураамжийг тухайн оны 3-р сарын 31-ний дотор бүтнээр, нэг удаа төлнө.

ЗУРГАА. ГИШҮҮНЭЭС ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЧӨЛӨӨЛӨХ

Дараах тохиолдолд гишүүн байгууллагыг гишүүнээс чөлөөлж, эрхийг түдгэлзүүлнэ.

- 6.1. Гишүүн байгууллага гишүүнчлэлийн хураамжийг тус журамд заасан хугацаанд төлөөгүй;
- 6.2. Гишүүнчлэлийн журмыг зөрчсөн;
- 6.3. МУҮХолбооноос зохион байгуулсан арга хэмжээнд 2 болон түүнээс дээш удаа зөрчил гаргасан;

ДОЛОО. БУСАД

- 7.1. Энэхүү журамд удирдах зөвлөлийн шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болно;
- 7.2. Гишүүн байгууллагууд нэмэлт өөрчлөлт оруулах санал ирүүлэх боломжтой;